



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/99/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: В.Цэнгэлмаа
Утас: 70584204 Цахим
хаяг: Tsengelmaav@audit.gov.mn
Аудитор: Ж.Баяртуул
Утас: 70584207 Цахим хаяг: bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	112
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	113
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	134
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	145
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16



БОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.18 № 85

танай _____ -ны № _____ -т

БАЯН-УУЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.БАТ-АМГАЛАН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520010



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Н.Бат-Амгалан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн хандиваар ирсэн хөрөнгийг баримтжуулах талаарх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 04-нөөс 2020 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 3/27 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.



Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх”-д оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 25 эрсдэлтэй асуудлыг төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 714,955.5 мянган төгрөгөөс тооцон 14,299.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 13,855.4 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.



2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82,386.7 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	91,215.6	92,378.2	1,162.6
Үндсэн хөрөнгө	5,229,032.6	5,314,725.9	85,693.3
Элэгдлийн зардал	-176,470.3	-180,939.5	-4,469.2
Нийт хөрөнгө	5,143,777.9	5,226,164.6	82,386.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,143,777.8	5,226,164.5	82,386.7
Хуримтлагдсан үр дүн	4,282,196.1	4,364,582.8	82,386.7
Өмнөх үеийн үр дүн	4,282,196.1	4,282,196.1	-
Тайлангийн үеийн үр дүн	-	82,386.7	82,386.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	125,167.04	125,167.04	-
Төрийн өмчийн оролцоо	736,414.7	736,414.7	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,143,777.9	5,226,164.6	82,386.7

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант жилд аймаг орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэснээс холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,226,164.5 мянган төгрөг болж 82,386.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилд суманд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг орлогоор бүртгэж авснаас шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газар тайлант онд 1'000.0 мянган төгрөгийн орлогыг цайны газрын туслах аж ахуйгаас төвлөрүүлэхээр батлагдсаныг бүрэн төвлөрүүлж ажилласан байна.



Хүснэгт 2: Төвлөрүүлэх орлого

/мян.төг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
Туслах үйл ажиллагаа	1,000.0	1,000.0	0	100.0
Нийт дүн	1,000.0	1,000.0	0	100.0

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 476,350.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд төлөвлөгдсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 455,138.4 мянган төгрөг буюу 95.6 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар онцгой байдлыг газраас шүлхий болон түймрийн гамшгийн үеийн томилолт болон шатахууны зардал шилжиж ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 25 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 17 эрсдэл тодорхойлж нийт 19 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 125,346.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 87,242.3 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулж, 37,737.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 364.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

1. Тайлант хугацаанд хийсэн 37,121.8 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв



2. Нөөцийн 616,0 мянган төгрөгийн бараа материалыг устгасан нь *Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”* гэсэн заалтыг заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Сумын ЗДТГ нь 1,000.0 мянган төгрөгийн нэмэлт орлого төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн боловч тус байгууллага нь тусгай зөвшөөрөлгүй нь *Төсвийн тухай хуулийн 44.1.1 дэх “төсвийн ерөнхийлөн захирагч урьдчилан бичгээр зөвшөөрсөн байх”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Аудитаар илэрсэн 364.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд сумын ИТХ-аар Хилийн 0275 дугаар ангид 1,626.0 мянган төгрөгийн үнэтэй дройныг худалдан авч сумын ИТХ-ын 2019.12.02-ны өдрийн 52 дугаар хуралдаанаар хөрөнгийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6.6.6 дахь “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн сумын төсвийн хөрөнгөөр улсын төсвийн байгууллагад хөрөнгө бэлтгэж, хөрөнгийг шилжүүлсэн байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баян-Уул сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тээврийн хэрэгслийн ашиглалт

1.1. Илрүүлэлт: Сумын Засаг даргын тамгын газрын дарга нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасны дагуу албан тушаалын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтад хамаарахгүй мөн тайлант онд 364.9 мянган төгрөгийн шатахууныг тодорхой ажлын гүйцэтгэлгүйгээр зарцуулсан байна.

1.2. Эрсдэл: Хууль журам хэрэгжихгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг мөрдөн ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	91 831 562,53	92 378 160,53
35	БАРАА МАТЕРИАЛ	91 215 562,53	92 378 160,53
351	Түүхий эд материал	171 266,45	171 266,45
35130	Эм боох материал	171 266,45	171 266,45
354	Хангамжийн материал	37 744 376,08	38 906 974,08
35410	Бичиг хэргийн материал	1 019 900,00	1 006 900,00
35420	Аж ахуйн материал	36 509 976,08	37 685 574,08
35430	Сэлбэг хэрэгсэл	214 500,00	214 500,00
35600	Мал амьтад	53 299 920,00	53 299 920,00
36	НӨӨЦИЙН БАРАА	616 000,00	-
36300	Тэжээлийн нөөц	616 000,00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5 051 946 295,59	5 133 786 376,35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5 051 946 295,59	5 133 786 376,35
391	Газар		
392	Биет хөрөнгө	4 997 664 295,59	5 078 793 149,29
39201	Барилга, байгууламж, орон сууц	524 649 564,81	582 551 064,81
39202	Хуримтлагдсан элэгдэл	(117 819 220,02)	(238 209 616,36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	115 309 057,00	172 309 057,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(64 953 841,31)	(89 814 293,47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47 987 956,00	64 613 721,00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16 229 622,47)	(23 636 871,80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42 834 518,33	46 653 118,33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18 794 660,43)	(22 607 410,62)
39214	Бусад үндсэн хөрөнгө	375 499 272,00	499 311 096,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(84 577 228,32)	(106 135 215,60)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	4 193 758 500,00	4 193 758 500,00
393	Биет бус хөрөнгө	54 282 000,00	54 993 227,06
39301	Програм хангамж	765 000,00	1 697 200,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(153 000,00)	(373 972,94)
39303	Бусад биет бус хөрөнгө	53 670 000,00	53 670 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5 143 777 858,12	5 226 164 536,88
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5 143 777 858,12	5 226 164 536,88
51	Засгийн газрын хувь оролцоо	5 143 777 858,12	5 226 164 536,88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	736 414 716,37	736 414 716,37
51101	Өмч: - төрийн	736 414 716,37	736 414 716,37
512	Хуримтлагдсан үр дүн	4 282 196 097,14	4 364 582 775,90
51210	Өмнөх үеийн үр дүн	4 282 196 097,14	4 282 196 097,14
51220	Тайлант үеийн үр дүн	-	82 386 678,76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	125 167 044,61	125 167 044,61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН	5 143 777 858,12	5 226 164 536,88



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	768 061 868,99	799 156 829,00
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	231 102 735,10	198 524 171,00
120	Нийтлэг татварын бүс орлого	13 896 535,10	1 000 000,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13 896 535,10	1 000 000,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1 000 000,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13 896 535,10	-
121	Хөрөнгийн орлого	217 206 200,00	197 524 171,00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө	-	-
	байгууллагын орлого	217 206 200,00	197 524 171,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	536 959 133,89	600 632 658,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	90 184 933,89	125 282 058,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	71 305 315,89	120 400 358,00
131105	Төсвийн урамшуулал	18 879 618,00	4 881 700,00
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	446 774 200,00	475 350 600,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн	446 774 200,00	475 350 600,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	714 955 891,96	692 833 850,20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	573 552 536,96	630 983 935,20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	542 473 235,96	608 705 939,20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230 250 630,00	246 538 936,00
210101	Үндсэн цалин	230 250 630,00	202 183 921,00
210105	Гэрээт ажлын хөлс	-	44 355 015,00
2102	Ажил олгогчдоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27 581 708,89	31 320 440,00
210201	Тэтгэврийн даатгал	18 559 939,89	21 296 370,00
210202	Тэтгэмжийн даатгал	2 371 133,00	2 462 829,00
210203	ҮОМЦО-ний даатгал	1 774 128,00	2 080 705,00
210204	Ажилгүйдлийн даатгал	435 906,00	504 506,00
210205	Эрүүл мэндийн даатгал	4 440 602,00	4 976 030,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26 882 741,00	35 145 000,00
210301	Гэрэл, цахилгаан	25 926 841,00	20 030 400,00
210302	Түлш, халаалт	955 900,00	15 114 600,00
2104	Хангамж, бараа материалын зардал	47 235 484,40	35 869 925,00
210401	Бичиг хэрэг	6 324 470,00	5 130 110,00
210402	Тээвэр, шатахуун	13 072 200,00	22 688 875,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 048 600,00	2 867 800,00
210404	Ном, хэвлэл	-	889 500,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 027 838,00	3 677 640,00
210408	Бараа материал асталсны зардал	24 762 376,40	616 000,00
2105	Нормативт зардал	6 344 200,00	5 218 100,00
210502	Хоол, хүнс	6 344 200,00	3 746 700,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1 471 400,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 000 000,00	14 302 470,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2 489 970,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	298 600,00
210604	Урсгал засвар	1 000 000,00	11 513 900,00
2107	Томилолт, зочны зардал	3 051 000,00	17 177 105,00
210702	Дотоод албан томилолт	3 051 000,00	13 748 855,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	3 428 250,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	8 318 930,00	13 753 020,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	7 156 840,00	12 310 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	180 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	712 090,00	644 580,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	324 040,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200 000,00	294 400,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200 000,00	-
210807	Газрын төлбөр	50 000,00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191 808 541,67	209 380 943,20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15 338 260,00	28 441 435,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрогдол	176 470 281,67	180 939 508,20
212	ТАТААС	3 000 000,00	-
2122	Хувийн хэвцлийн байгууллагад олгох татаас	3 000 000,00	-
212201	Хувийн хэвцлийн байгууллагад олгох татаас	3 000 000,00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28 079 301,00	22 277 996,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1 065 800,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1 065 800,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28 079 301,00	21 212 196,00
213303	Төвлөрүүдэх шилжүүлэг	28 079 301,00	21 212 196,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	141 403 355,00	61 849 915,00
2200	Дотоод эх уусварээр	141 403 355,00	61 849 915,00
223001	Бусад хөрөнгө	141 403 355,00	61 849 915,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	53 105 977,03	106 322 978,80
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ЗАРДЛЫН ДҮН	1 429 674 774,20	23 936 300,04
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	440 906 455,11	23 936 300,04
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	988 768 319,09	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ҮР ДҮН (4)=(145-225)	(1 429 674 774,20)	(23 936 300,04)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1 376 568 797,17)	82 386 678,76



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	536 959 133,89	601 632 658,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1 000 000,00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1 000 000,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1 000 000,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1 000 000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	536 959 133,89	600 632 658,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	90 184 933,89	125 282 058,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71 305 315,89	120 400 358,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18 879 618,00	4 881 700,00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	446 774 200,00	475 350 600,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	446 774 200,00	475 350 600,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	373 083 778,89	469 991 315,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	373 083 778,89	469 991 315,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	342 004 477,89	447 713 319,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	230 250 630,00	246 538 936,00
210101	Үндсэн цалин	230 250 630,00	202 183 921,00
210105	Гэрээт ажлын хөлс	-	44 355 015,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27 581 708,89	31 320 440,00
210201	Тэтгэврийн даатгал	18 559 939,89	21 296 370,00
210202	Тэтгэмжийн даатгал	2 371 133,00	2 462 829,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 774 128,00	2 080 705,00
210204	Ажилгүйдлийн даатгал	435 906,00	504 506,00
210205	Эрүүл мэндийн даатгал	4 440 602,00	4 976 030,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26 882 741,00	35 145 000,00
210301	Гэрэл, цахилгаан	25 926 841,00	20 030 400,00
210302	Түлш, халаалт	955 900,00	15 114 600,00
2104	Хангамж, бараа материалын зардал	23 237 008,00	35 364 925,00
210401	Бичиг хэрэг	7 088 370,00	5 117 110,00
210402	Тээвэр, шатахуун	13 072 200,00	22 688 875,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 048 600,00	2 867 800,00
210404	Ном, хэвлэл	-	889 500,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 027 838,00	3 801 640,00
2105	Нормативт зардал	6 344 200,00	5 218 100,00
210502	Хоол, хүнс	6 344 200,00	3 746 700,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1 471 400,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 000 000,00	23 070 158,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	7 125 458,00
210602	Тавилга	-	3 818 600,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	612 200,00
210604	Урсгал засвар	1 000 000,00	11 513 900,00
2107	Томиллолт, зочны зардал	3 051 000,00	17 177 105,00
210702	Дотоод албан томилолт	3 051 000,00	13 748 855,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	3 428 250,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8 318 930,00	25 437 220,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7 156 840,00	16 480 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	180 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	712 090,00	644 580,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	324 040,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200 000,00	294 400,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200 000,00	7 514 200,00
210807	Газрын төлбөр	50 000,00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15 338 260,00	28 441 435,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15 338 260,00	28 441 435,00
212	ТАТААС	3 000 000,00	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3 000 000,00	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	3 000 000,00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28 079 301,00	22 277 996,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1 065 800,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1 065 800,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28 079 301,00	21 212 196,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28 079 301,00	21 212 196,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	163 875 355,00	131 641 343,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	163 875 355,00	131 641 343,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	163 875 355,00	131 641 343,00
2200	Дотоод эх үүсвэрээр	163 875 355,00	131 641 343,00
223001	Бусад хөрөнгө	163 875 355,00	131 641 343,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(163 875 355,00)	(131 641 343,00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	736 414 716,37	125 167 044,61	4 282 196 097,14	0,00	5 143 777 858,12
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	736 414 716,37	125 167 044,61	4 282 196 097,14	0,00	5 143 777 858,12
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	736 414 716,37	125 167 044,61	4 282 196 097,14	0,00	5 143 777 858,12
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	736 414 716,37	125 167 044,61	4 282 196 097,14	0,00	5 143 777 858,12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	0,00	0,00	0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	736 414 716,37	125 167 044,61	4 282 196 097,14	0,00	5 143 777 858,12
D08	Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	82 386 678,76	0,00	82 386 678,76
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	736 414 716,37	125 167 044,61	4 364 582 775,90	0,00	5 226 164 536,88



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	476 350 600,00	455 138 404,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	427 350 600,00	406 138 404,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	426 284 800,00	405 072 604,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260 062 100,00	246 538 936,00
210101	Үндсэн цалин	218 271 700,00	202 183 921,00
210105	Гэрээт ажлын хөлс	41 790 400,00	44 355 015,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32 507 800,00	31 320 440,00
210201	Тэтгэврийн даатгал	22 105 500,00	21 296 370,00
210202	Тэтгэмжийн даатгал	2 600 700,00	2 462 829,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 080 400,00	2 080 705,00
210204	Ажилгүйдлийн даатгал	519 800,00	504 506,00
210205	Эрүүл мэндийн даатгал	5 201 400,00	4 976 030,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35 145 000,00	35 145 000,00
210301	Гэрэл, цахилгаан	29 245 000,00	20 030 400,00
210302	Түлш, халаалт	5 900 000,00	15 114 600,00
2104	Хангамж, бараа материалын зардал	33 294 300,00	32 404 700,00
210401	Бичиг хэрэг	5 571 400,00	5 017 110,00
210402	Тээвэр, шатахуун	20 612 200,00	19 828 650,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 706 000,00	2 867 800,00
210404	Ном, хэвлэл	1 250 000,00	889 500,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3 154 700,00	3 801 640,00
2105	Нормативт зардал	1 471 400,00	1 471 400,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 471 400,00	1 471 400,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25 964 000,00	23 070 158,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9 970 000,00	7 125 458,00
210602	Тавилга	5 540 000,00	3 818 600,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	640 000,00	612 200,00
210604	Урсгал засвар	9 814 000,00	11 513 900,00
2107	Томилолт, зочны зардал	13 396 000,00	12 370 750,00
210702	Дотоод албан томилолт	9 396 000,00	8 942 500,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4 000 000,00	3 428 250,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9 344 200,00	8 957 220,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180 000,00	180 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	900 000,00	644 580,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	380 000,00	324 040,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	320 000,00	294 400,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7 514 200,00	7 514 200,00
210807	Газрын төлбөр	50 000,00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15 100 000,00	13 794 000,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15 100 000,00	13 794 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1 065 800,00	1 065 800,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1 065 800,00	1 065 800,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1 065 800,00	1 065 800,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	49 000 000,00	49 000 000,00
2200	Дотоод эх үүсвэрээр	49 000 000,00	49 000 000,00
223001	Бусад хөрөнгө	49 000 000,00	49 000 000,00

